

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧДАД
ЗОРИУЛСАН
КОРОНАВИРУС 2019 (КОВИД-19) ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
СПАЙКВАКС (КОВИД-19 ВАКЦИН, мРНХ), МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН,
МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН (ЭХ ХУВЬ БА ОМИКРОН ВА.4/ВА.5)
ВАКЦИНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС**

6 БА ҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫХАНД

Танд болон таны хүүхдэд SARS-CoV-2 коронавирусаар халдварладаг Коронавирус 2019 (КОВИД-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин (Эх хувь ба Омикрон ВА.4/ВА.5, цаашид "Модерна КОВИД-19, Бивалент вакцин" гэх)-ыг санал болгож байна.

Энэхүү вакцины мэдээллийн хуудас нь үйлчлүүлэгч болон эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан 6 ба түүнээс дээш насны хүмүүст хэрэглэхээр зөвшөөрөгдсөн Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин, АНУ-ын ХЭЗ-аас 12 ба түүнээс дээш насныханд зориулсан СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ) вакцины тухай мэдээллийг багтаасан.¹

Хэрэглэх зааварчилгааны дагуу бэлтгэсэн тохиолдолд FDA-зөвшөөрөлтэй СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ) ба Яаралтай Хэрэглэх зөвшөөрөлтэй (EUA) Пфайзер-БиоНТек КОВИД-19 вакциныг 12 ба түүнээс дээш насныханд аюулгүй байдал, үр дүнгийн асуудалгүйгээр ээлжилж хэрэглэж болно.²

СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ) нь ModernaTX, Inc-ийн үйлдвэрлэсэн FDA-баталгаажуулалттай КОВИД-19-ийн вакцин юм. Үүнийг КОВИД-19-ээс сэргийлэх журмаар 18 нас ба түүнээс дээш насныханд 2 тунгийн цуврал байдлаар хийхийг зөвшөөрсөн. Мөн доорх тохиолдлуудад ЯХЗ-тэй хэрэглэхийг зөвшөөрсөн:

- 12-оос 17 насныханд хийх анхан шатны цувралын 2 тун;
- тодорхой төрлийн дархлаа султай болох нь тогтоогдсон 12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулсан анхан шатны цувралын гурав дахь тун.

¹ Таны хүүхэд 5 настай байсан ч та энэхүү Вакцины мэдээллийн хуудсыг авч болно. Анхан шатны цувралын тун хооронд 5 наснаас 6 нас хүрэх хүүхдүүд аль ч тунг хийлгэх боломжтой: (1) 6 сараас 5 хүртэлх насныханд хэрэглэхийг зөвшөөрсөн Модерна КОВИД-19 вакцин; (2) 6 наснаас 11 хүртэлх насныханд хэрэглэхийг зөвшөөрсөн Модерна КОВИД-19 вакцин.

Анхдагч цувралын тун хооронд 11-ээс 12 хүртэлх насны хүүхдүүд анхан шатны цувралын аль ч тунг хийлгэх боломжтой: (1) 6-аас 11 нас хүртэлх насныханд хэрэглэхийг зөвшөөрсөн Модерна КОВИД-19 вакцин; (2) 12 ба түүнээс дээш насныханд хэрэглэхийг зөвшөөрсөн Модерна КОВИД-19 вакцин; (3) СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ).

²FDA-аас зөвшөөрөгдсөн СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ) болон ЯХЗ-тэй Модерна КОВИД-19 вакцины нэг тунг (улаан тагтай, цайвар цэнхэр хүрээтэй шошготой шилэнд савласан) ямар нэгэн аюулгүй байдал, үр дүнгийн асуудалгүйгээр 12 ба түүнээс дээш насны хүмүүст анхан шатны цувралыг сольж хэрэглэж болно.

АНУ-ын Хүнс, эмийн чанарын хяналтын газраас Модерна КОВИД-19 вакциныг ЯХЗ олгосон:

- 6 ба түүнээс дээш насны хүмүүст зориулсан анхан шатны цувралын хоёр тун;
- тодорхой төрлийн дархлаа султай болох нь тогтоогдсон 6 ба түүнээс дээш насны хүмүүст зориулсан анхан шатны цувралын гурав дахь тун.

АНУ-ын ХЭЗ-аас дараах тохиолдолд Модерна КОВИД-19, Бивалент вакцинд ЯХЗ олгосон:

- зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан моновалент³ КОВИД-19 вакцины анхан шатны вакцинд хамрагдсан 6 ба түүнээс дээш насны хүмүүст хамгийн багадаа 2 сарын дараа нэмэлт нэг тун хийх;
- зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан моновалент КОВИД-19 вакцины хамгийн сүүлийн нэмэлт тун хийлгэсэн 6 ба түүнээс дээш насны хүмүүст хамгийн багадаа 2 сарын дараа нэмэлт нэг тун хийх.

Энэхүү Вакцины Мэдээллийн Хуудас нь танд өнөөгийн КОВИД-19 цар тахлын улмаас танд олон таны хүүхдэд хийж болзошгүй СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцины давуу тал, эрсдэлүүдийн талаар ойлгоход туслах мэдээлэл агуулдаг. Хэрэв танд асууж лавлах зүйл байвал вакцин нийлүүлэгчтэй холбоо барина уу.

СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин нь хүн бүрийг хамгаалж чадахгүй байж болзошгүй.

Энэхүү Мэдээллийн Хуудас цаашид шинэчлэгдэнэ. Хамгийн сүүлийн Мэдээллийн Хуудсыг www.modernatx.com/covid19vaccine-eua вебсайтаас үзнэ үү.

ТА БОЛОН ТАНЫ ХҮҮХЭД ЭНЭ ВАКЦИНЫГ ХИЙЛГЭХИЙН ӨМНӨ ТА ЯМАР МЭДЭЭЛЭЛ АВАХ ХЭРЭГТЭЙ ВЭ

КОВИД-19 ГЭЖ ЮУ ВЭ?

КОВИД-19 өвчин нь SARS-CoV-2 хэмээх коронавирусаас үүсдэг. Энэ төрлийн коронавирус урьд өмнө гарч байгаагүй. Та вирус тээж буй хүнтэй харьцсанаар КОВИД-19-ийн халдвар авч болзошгүй. Энэ бол ихэвчлэн бусад эрхтэнд нөлөөлж болзошгүй амьсгалын замын өвчин юм. КОВИД-19-ийн халдвар авсан хүмүүст хөнгөн хэлбэрээс эхлээд хүнд хэлбэрийн өвчний олон төрлийн шинж тэмдэг илэрсэн гэж бүртгэгдсэн. Вирусын халдвар авснаас хойш 2-14 хоногийн дараа шинж тэмдэг илэрч болно. Шинж тэмдгүүд доорхийг нэгтгэнэ: халуурах; бие арзайх; ханиах; амьсгалахад хүндрэлтэй болох; ядрах; булчин ба бие өвдөх; толгой өвдөх; үнэртэх болон амтлах чадвараа алдах; хоолой хөндүүрлэх; хамар битүүрэх; нус гоожих; дотор муухайрах; бөөлжих; гүйлгэх.

СПАЙКВАКС (КОВИД-19 ВАКЦИН, мРНХ), МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХООРОНДОО ХЭРХЭН ХОЛБОГДДОГ ВЭ?

СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ) болон Модерна КОВИД-19, Бивалент вакциныг сольж хэрэглэж болно.⁴Модерна КОВИД-19, Бивалент вакцинтай адил аргаар үйлдвэрлэсэн⁴Модерна КОВИД-19, Бивалент вакцин нь адил аргаар хийгдсэн

³ Моновалент гэдэг нь зөвхөн анхны SARS-CoV-2-ын баяжуулалтын уураг агуулсан эсвэл кодолсон аливаа зөвшөөрөгдсөн буюу батлагдсан КОВИД-19 вакциныг хэлнэ.

⁴FDA-аас зөвшөөрөгдсөн СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ) болон ЯХЗ-тэй Модерна КОВИД-19 вакцины нэг тунг (улаан тагтай, цайвар цэнхэр хүрээтэй шошготой шилэнд савласан) сольж хэрэглэж болно

СПАЙКВАКС болон Модерна КОВИД-19 вакцин нь SARS-CoV-2-ын Омикрон хувилбараас үүдэлтэй КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх Омикрон бүрэлдэхүүн хэсгийг агуулдаг.

ЯХЗ-ийн дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Мэдээллийн Хуудасны төгсгөлд буй “Яаралтай хэрэглэх зөвшөөрөл (EUA) гэж юу вэ?” хэсгийг үзнэ үү.

ТА БОЛОН ТАНЫ ХҮҮХЭД ЭДГЭЭР ВАКЦИНЫ АЛЬ НЭГИЙГ ХИЙЛГЭХЭЭС ӨМНӨ ВАКЦИН НИЙЛҮҮЛЭГЧДЭЭ ЮУГ МЭДЭЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

Та болон таны хүүхэд вакцин нийлүүлэгчдээ эрүүл мэндийн байдлынхаа талаар доорх мэдээллийг өгөх хэрэгтэй:

- ямар нэгэн харшилтай эсэх
- өмнө нь миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардит (зүрхний гаднах бүрхүүлийн үрэвсэл) зэрэг өвчнөөр өвдөж байсан эсэх
- халуурч байгаа эсэх
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг эсэх
- дархлаа суларсан эсвэл та болон таны хүүхэд дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг эсэх
- жирэмсэн эсвэл жирэмслэх төлөвлөгөөтэй
- хөхүүл
- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин тариулсан
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан

ХЭН СПАЙКВАКС (КОВИД-19 ВАКЦИН, мРНХ), МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХИЙЛГЭЖ БОЛОХГҮЙ ВЭ?

Дараах тохиолдолд та болон таны хүүхэд эдгээр вакцины аль нэгийг нь хийлгэж болохгүй:

- СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ) эсвэл Модерна КОВИД-19 вакцины өмнөх тунг хийлгэсний дараа харшлын хүнд урвал илэрсэн
- эдгээр вакцины аль нэг найрлагад хүчтэй харшлын урвал үзүүлсэн

ЭДГЭЭР ВАКЦИНЫ НАЙРЛАГАД ЯМАР БОДИСУУД ОРСОН БЭ?

СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин нь доорх найрлагатай: мессенжер рибонуклеины хүчил (mRNA), липидүүд (SM-102, полиэтилен гликол [PEG] 2000 димиристойл глицерол [DMG], холестерин, 1,2-дистеароил-сн-глицеро-3-фосфохолин [DSPC]), трометамин, трометамин гидрохлорид, цууны хүчил, натрийн ацетат трихидрат, сахароз.

ЭДГЭЭР ВАКЦИНЫГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19 Бивалент вакциныг танд эсвэл таны хүүхдэд булчинд тарих хэлбэрээр хийнэ.

12 ба түүнээс дээш насны хүмүүст зориулсан анхан шатны цувралын хувьд аюулгүй байдал, үр дүнгийн асуудалгүй.

Анхан шатны цуврал: СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ) болон Модерна КОВИД-19 вакциныг 1 сарын зайтай хоёр тунгаар хийнэ. Зарим төрлийн дархлаа султай хүмүүст хоёр дахь тунгаас хойш дор хаяж 1 сарын дараа анхан шатны цувралын гурав дахь тунг хийж болно.

Нэмэлт тун: Дараах тохиолдолд Модерна КОВИД-19, Бивалент вакциныг нэг удаагийн нэмэлт тунгаар дор хаяж 2 сарын дараа хэрэглэнэ:

- зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан моновалент КОВИД-19 вакцины анхан шатны вакцинжуулалт дууссан;
- зөвшөөрөгдсөн эсвэл батлагдсан моновалент КОВИД-19 вакцины хамгийн сүүлийн нэмэлт тунг хийлгэсэн.

ЭДГЭЭР ВАКЦИНЫГ ӨМНӨ НЬ ХИЙЖ БАЙСАН УУ?

2020 оны 12 сарын 18-наас хойш 18 болон түүнээс дээш насны сая, сая хүмүүс EUA-ийн хяналтан дор Модерна КОВИД-19 вакциныг хийлгэсэн. Клиник тандалтаар 12 ба түүнээс дээш насны 30,000 орчим хүн, 6-аас 11 нас хүртэлх 4,000 хүн, 6 сараас 5 нас хүртэлх 5,000 хүн Модерна КОВИД-19 вакцины дор хаяж 1 тунд хамрагдсан байна.

Клиник тандалтаар 18 ба түүнээс дээш насны ойролцоогоор 400 хүн Модерна КОВИД-19, Бивалент вакцинаас Омекрон бүрэлдэхүүнтэй гэдгээрээ ялгаатай бивалент вакцины 1 тунг хийлгэсэн.

ЭДГЭЭР ВАКЦИНЫ АШИГ ТУС НЬ ЮУ ВЭ?

СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ), Модерна КОВИД-19 вакциныг КОВИД-19 цар тахлаас сэргийлэх зорилгоор хэрэглэнэ. ХЭЗ нь SARS-CoV-ий Омекрон хувилбараас үүдэлтэй КОВИД-19-өөс илүү сайн хамгаалахын тулд Модерна КОВИД-19, Бивалент вакциныг зөвшөөрсөн.

КОВИД-19-ээс хамгаалах чадвар үргэлжлэх хугацаа тодорхой бус байна.

ЭДГЭЭР ВАКЦИНЫ ЭРСДЭЛ ЮУ ВЭ?

Эдгээр вакцин нь хүнд хэлбэрийн харшлын урвал үүсгэх магадлал багатай. Хүнд хэлбэрийн харшлын хүнд урвал нь вакцины тунг хийлгэсний дараа хэдэн минутаас нэг цагийн дотор илэрнэ. Энэ шалтгаанаар вакцины үйлчилгээ үзүүлэгч вакцин хийлгэсний дараа та болон таны хүүхдийн биеийн байдлыг хянахаар вакцин хийлгэсэн байранд хэсэг хугацаанд байх хүсэлт тавина. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдэг:

- Амьсгалахад хүндрэлтэй болох
- Нүүр, хоолой хавагнах
- Зүрх хурдан цохилох
- Биеийн бүх хэсэгт тууралт гарах
- Толгой эргэх, сульдах

СПАЙКВАКС КОВИД-19 эсвэл Модерна COVID-19 вакцин хийлгэсэн эмэгтэйчүүд, өндөр настай эрчүүдтэй харьцуулахад 40-өөс доош насны эрчүүдэд миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) болон перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл) илүү их тохиолдсон. Энэ хүмүүсийн ихэнхэд нь вакцины хоёр дахь тунг хийлгэснээс хойш хэдхэн хоногийн дотор шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол гарах магадлал Хянасан: 2022/10/12

маш бага байдаг. Вакцин хийлгэсний дараа танд болон таны хүүхдэд дараах шинж тэмдэг илэрвэл та даруй эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Цээжээр өвдөх
- Амьсгал давчдах
- Зүрх хурдан, жигд бус, дэлсэх мэдрэмж төрөх

Вакцины клиник тандалтын үед дараах сөрөг нөлөө бүртгэгдсэн:

- Тариа хийсэн хэсгийн урвалууд: тариа хийлгэсэн гарын тунгалгийн булчирхай өвдөх, хөндүүрлэх, хавдах, мөн хатуурч хавдах (хатуурах), улайх
- Ерөнхий сөрөг нөлөө: ядрах, толгой өвдөх, булчин өвдөх, үе мөч өвдөх, жихүүдэс хүрэх, дотор муухайрах, бөөлжих, халуурах, тууралт гарах

Вакцин хэрэглэх зөвшөөрөл авсны дараа доорх сөрөг нөлөө мэдэгдсэн:

- Хүнд хэлбэрийн харшлын урвал
- Миокардит (зүрхний булчингийн үрэвсэл)
- Перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл)
- Вакцин хийлгэсэнтэй холбоотойгоор ухаан алдах

Эдгээр нь вакцины бүх байж болох сөрөг нөлөө биш ч байж болно. Ноцтой ба гэнэтийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Эдгээр вакцины сөрөг нөлөөг судалж байгаа хэвээр байна.

СӨРӨГ НӨЛӨӨ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД БИ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Хэрвээ танд болон таны хүүхдэд хүнд хэлбэрийн харшлын урвал илэрвэл 9-1-1 утас руу залгах эсвэл хамгийн ойрын эмнэлэгт хандана уу.

Хэрэв таны болон хүүхдэд тань илэрсэн сөрөг нөлөө арилахгүй хэвээр байвал вакцины үйлчилгээ үзүүлэгч эсвэл хүүхдийнхээ эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.

Вакцины сөрөг нөлөөг **АНУ-ын ХЭЧХГ/ХӨХУСТ-ийн (CDC) Вакцины сөрөг нөлөөний талаар мэдээлэх систем (V-safe)** -д мэдээлэх. V-safe-ийн 1-800-822-7967 үнэгүй утасны дугаар эсвэл <https://vaers.hhs.gov/reportevent.html> вебсайтад онлайн горимд мэдээлнэ үү. Тайлангийн маягтын #18 хайрцагийн эхний шугамд "СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ)", "Модерна КОВИД-19 Вакцин EUA", "Модерна КОВИД-19, Бивалент вакцин гэж оруулна уу.

Түүнчлэн та сөрөг нөлөөний талаар 1-866-MODERNA (1-866-663- 3762) утсаар ModernaTX, Inc-д мэдээлж болно.

Мөн та **v-safe системд бүртгүүлэх боломжтой**. **V-safe** бол КОВИД-19 вакцины дараах болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлохын тулд вакцин хийлгэсэн хүмүүсийг хянах зорилгоор текст мессеж, вебсайтын судалгаа ашигладаг, дурын ухаалаг гар утсанд суурилуулсан хэрэгсэл юм. **V-safe** систем ХӨХУСТ-ийн КОВИД-19 вакцины аюулгүй байдлыг хянахад туслах асуултууд асуудаг. Мөн **V-safe** системээс КОВИД-19 вакцин хийлгэсний дараа хамрагдагсдын эрүүл мэндэд ихээр нөлөөлсөн гэж мэдээлсэн тохиолдолд ХӨХУСТ-өөс утсаар шууд хяналт тавьдаг. Дэлгэрэнгүй мэдээлэл авахаар www.cdc.gov/vsafe вебсайтад хандана уу.

ХЭРЭВ БИ ӨӨРТӨӨ БОЛОН ХҮҮХДЭДЭЭ СПАЙКВАКС (КОВИД-19 ВАКЦИН, мРНХ), МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХИЙЛГЭХ ХҮСЭЛГҮЙ ТОХИОЛДОЛД ЯАХ ВЭ?

ЕУА-аар та вакцинд хамрах эсэхээ өөрөө шийднэ. Та өөртөө болон хүүхэддээ эдгээр вакцины аль нэгийг хийлгэхгүй гэж шийдсэн нь таны хүүхдийн эмнэлгээс стандарт тусламж авахад нөлөөлөхгүй.

СПАЙКВАКС (КОВИД-19 ВАКЦИН, мРНХ), МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИНААС ӨӨР КОВИД-19-ЭЭС ХАМГААЛАХ ӨӨР СОНГОЛТ БАЙДАГ УУ?

12 болон түүнээс дээш насны хүмүүсийн хувьд КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх өөр сонголт бол ХЭЗ-аас батлагдсан КОВИД-19 вакцин болох КОМАРНИТИ (КОВИД-19 вакцин, мРНХ)

вакцин хийлгэх юм. 6 болон түүнээс дээш насны хүмүүс SARS-CoV-2-ын Омикрон бүрэлдэхүүн агуулсан бивалент вакцин зэрэг КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх бусад вакцинуудыг ЯХЗ-ийн хүрээнд хийлгэх боломжтой.

БИ БОЛОН МИНИЙ ХҮҮХЭД СПАЙКВАКС (КОВИД-19 ВАКЦИН, мРНХ), МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИНЫГ БУСАД ВАКЦИНУУДАТ ХАМТ ХЭРЭГЛЭЖ БОЛОХ УУ?

СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакциныг бусад вакцинуудтай хамтран хэрэглэсэн мэдээлэл ХЭЗ-нд хараахан ирээгүй байна. Хэрвээ та өөртөө болон хүүхэддээ СПАЙКВАКС (КОВИД-19 Вакцин, мРНХ), Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакциныг бусад вакцинуудтай хамт хийлгэх хүсэлтэй бол хариуцсан эрүүл мэндийн ажилтантайгаа ярилцана уу.

ХЭРЭВ БИ БОЛОН МИНИЙ ХҮҮХЭД ДАРХЛАА СУЛТАЙ БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв таны болон хүүхдийн тань дархлаа сул байгаа бол та Модерна КОВИД-19 вакцин эсвэл СПАЙКВАКС (КОВИД-19 вакцин, мРНХ)-ын анхан шатны гурав дахь тунг хийлгэх боломжтой. 6 ба түүнээс дээш насны хүмүүс Модерна КОВИД-19, Бивалент вакцины нэмэлт тунг хийлгэж болно. Вакцинжуулалт нь дархлаа султай хүмүүст КОВИД-19-ийн бүрэн дархлаа тогтоохгүй байж болзошгүй тул та өөрийгөө болон хүүхдээ КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэхийн тулд бодит арга хэмжээг үргэлжлүүлэх хэрэгтэй. Мөн таны ойр дотны хүмүүс зохих ёсоор вакцинжуулалтад хамрагдах хэрэгтэй.

ЖИРЭМСЭН ЭСВЭЛ ХӨХҮҮЛ БОЛ ЯАХ ВЭ?

Хэрэв та жирэмсэн эсвэл хүүхдээ хөхөөр хооллодог бол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ сонголтынхоо тухай ярилцаарай.

ЭДГЭЭР ВАКЦИН НАДАД БОЛОН МИНИЙ ХҮҮХДЭД КОВИД-19-ИЙГ ХАЛДААХ УУ?

Үгүй. Эдгээр вакцин нь SARS-CoV-2-ыг агуулдаггүй тул танд болон таны хүүхдэд КОВИД-19 халдаахгүй.

ВАКЦИНЖУУЛАЛТЫН КАРТАА ХАДГАЛНА УУ


Та болон таны хүүхэд КОВИД-19 вакцины эхний тунг хийлгэхэд вакцины карт олгоно. Та эргэж ирэхдээ картаа авчрахаа мартуузай.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Хэрэв танд асууж лавлах зүйл байвал вебсайтад зочлох эсвэл доорх утсаар холбогдоно

уу. Хамгийн сүүлийн Мэдээллийн хуудаст нэвтрэхийн тулд доор өгөгдсөн QR кодыг

сканердана уу.

Модерна КОВИД-19 вакцины вебсайт	Утасны дугаар
www.modernatx.com/covid19vaccine-eua 	1-866-MODERNA (1-866-663-3762)

БИ ХЭРХЭН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ВЭ?

- Вакцин хийлгэсэн байгууллагаас лавлаж асууна уу
- ХӨХУСТ-д вебсайтад <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/index.html> холбоосоор нэвтрэнэ үү
- АНУ-ын ХЭЧХГ-ын вебсайтад <https://www.fda.gov/emergency-preparedness-and-response/mcm-legal-regulatory-and-policy-framework/emergency-use-authorization> холбоосоор нэвтрэнэ үү
- Муж эсвэл орон нутгийнхаа нийгмийн эрүүл мэндийн хэлтэстэй холбогдоно уу

ВАКЦИНЖУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ ХААНА ХАДГАЛАГДАХ ВЭ?

Вакцин нийлүүлэгч нь таны болон таны хүүхдийн вакцинжуулалтын мэдээллийг танай муж/орон нутгийн харъяа Дархлаажуулалтын Мэдээллийн Тогтолцоо (IIS) эсвэл бусад тусгай системд оруулна. Энэ нь та болон таны хүүхэд анхан шатны хоёр дахь тунгаа хийлгэхээр буцаж ирэхдээ адил вакцин хийлгэх баталгаа болно. ДМС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг:

<https://www.cdc.gov/vaccines/programs/iis/about.html> холбоосоор нэвтрэж авна уу.

БИ ЭДГЭЭР КОВИД-19 ВАКЦИН ХИЙЛГЭСНЭЭР ЗАХИРГААНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ ҮҮ?

Үгүй. Энэ удаа нийлүүлэгч танаас вакцины тунгийн төлбөр авахгүй бөгөөд та зөвхөн КОВИД-19 вакцин хийлгэсэн тохиолдолд вакцин хийлгэсэн болон бусад хураамжийг танаар төлүүлэхгүй. Гэвч вакцин нийлүүлэгчид вакцинд хамрагдсан хүмүүст вакцины захиргааны төлбөрийг аливаа хөтөлбөр, төлөвлөгөөний (хувийн даатгал, Medicare, Medicaid, даатгалгүй вакцин хийлгэгчдэд зориулсан HRSA COVID-19 Uninsured Program) дагуу зохих нөхөн олгох арга зам эрэлхийлнэ.

БИ ЗАЛИЛИНГИЙН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫГ ХААНА МЭДЭЭЛЭХ ВЭ?

ХӨХУСТ-ийн КОВИД-19 Вакцинжуулалтын Хөтөлбөрийг ямар нэгэн байдлаар зөрчсөн тухай мэдээл авсан хүмүүс АНУ-ын Эрүүл мэнд, хүний нөөцийн үйлчилгээний газрын Ерөнхий хянан шалгах хэлтэст 1-800-NHS-TIPS утас эсвэл TIPS.NHS.GOV вебсайтад хандаж мэдээлнэ үү.

ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Хохирлын нөхөн төлбөрийн хөтөлбөр (CICP) нь тодорхой эм, вакцин, түүний дотор эдгээр вакцинаас болж ноцтой хохирсон хүмүүсийн эмчилгээний зардал, бусад тодорхой зардлуудыг нөхөн төлөхөд туслах холбооны хөтөлбөр юм. Ерөнхийдөө вакцин хийлгэснээс нэг (1) жилийн дотор ХНТХ-г өргөдөл гаргах ёстой. Хэнд

Энэхүү хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл www.hrsa.gov/cicp/ [вебсайтад нэвтэрч/](#) эсвэл 1-855-266-2427 утсаар холбогдоно уу.

ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ (EUA)?

Яаралтай Хэрэглээний Зөвшөөрөл (EUA) гэдэг нь КОВИД-19 тар тахал зэрэг нийтийн эрүүл мэндийн онцгой байдлын үед вакцин гэх мэт эрүүл мэндийн бүтээгдэхүүний олдоц, ашиглах боломжийг хөнгөвчлөх механизм юм. EUA нь Эрүүл Мэндийн Алба ба Хүний Үйлчилгээ (HHS)-ээс дэмжигддэг ба КОВИД-19 цар тахлын үед биологийн ба эмийн бүтээгдэхүүнүүдийг яаралтай хэрэглэх баталгааг гаргадаг. Яаралтай хэрэглэх зөвшөөрөл авсан бүтээгдэхүүн нь FDA-аас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнтэй адил төрлийн FDA-н хяналтад хамрагдаагүй.

АНУ-ын ХЭЧХГ нь өөр ямар нэгэн адил төстэй, батлагдсан, боломжит хувилбар байхгүй гэсэн тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд ЯХЗ олгоно. Мөн түүнчлэн АНУ-ын ХЭЧХГ-ын шийдвэр уг бүтээгдэхүүн КОВИД-19 цар тахлын үеэр КОВИД-19-өөс сэргийлэхэд үр дүнтэй, мөн тухайн бүтээгдэхүүний мэдэгдэж байгаа болон боломжит үр дүн нь мэдэгдэж байгаа болон болзошгүй эрсдэлээс илүү их нөлөөтэй гэдгийг шинжлэх ухааны бүх нотолгоонд үндэслэсэн байна. Бүтээгдэхүүнийг КОВИД-19 цар тахлын үед ашиглахын тулд эдгээр бүх шалгуурыг хангасан байх ёстой.

ЯХЗ нь бүтээгдэхүүнийг цуцлах эсвэл хүчингүй болгохоос бусад тохиолдолд (үүний дараа бүтээгдэхүүнийг цаашид ашиглахгүй) яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн КОВИД-19-ийн мэдэгдлийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Moderna US, Inc.
Cambridge, MA 02139

©2022 ModernaTX, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Патент:
www.modernatx.com/patents Хянасан:
2022/10/12



Энэхүү Мэдээллийн хуудсыг вакцин хийлгэсэн хүмүүсийн эрүүл мэндийн цахим бүртгэл/дархлаажуулалтын мэдээллийн системд оруулсныг батлахын тулд сканердаж үзнэ үү.

ББГДТ: 0886983000349